



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 219 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 377,017,720.00 (гурван зуун далан долоон сая арван долоон мянга долоон зуун хорин) төгрөгийн балансын үнэ, 82,399,633.13 (наян хоёр сая гурван зуун ерэн есөн мянга зургаан зуун гучин гурван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 4 ширхэг барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдсугай.

2.Нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тооцож, нийт худалдах доод үнийг 188,530,000.00 (нэг зуун наян найман сая таван зуун гучин мянган) төгрөгөөр, дэнчингийн хэмжээг 33,807,500.00 (гучин гурван сая найман зуун долоон мянга таван зуун) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

3. Төрийн банкны гүйцэтгэх захирал Г.Дөлгөөнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан 4 ширхэг барилгын нээлттэй дуудлагын худалдааг холбогдох хууль, захиргааны актын дагуу зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

3.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0001977



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн
өдрийн 289 дугаар тогтролын хавсралт

Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах барилгын жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арал	Балансад бүртгэсэн он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЭГ-ын 2017 оны 12 дугаар тэмдэглэл 3Г-ын 2017 оны 219 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Архангай аймаг Эрдэнэбулган сумын 2-р баг Тооцооны төвийн барилга	2008	266,491,560.00	55,542,484.51	210,949,075.49	266,500,000.00	133,250,000.00	19,987,500.00
2	Хөвсгөл, Мөрөн сум 8-р баг Тооцооны төвийн барилга	2003	63,282,660.00	15,451,560.94	47,831,099.06	63,300,000.00	31,650,000.00	7,912,500.00
3	Сэлэнгэ, Алтанбулаг сум 1-р баг 3-р байрны 8 тоот Тооцооны төвийн барилга	2004	33,689,970.00	8,301,778.34	25,388,191.66	33,700,000.00	16,850,000.00	4,212,500.00
4	Дархан-Уул, Дархан сум 16-р баг автомашины гарааш	2002	13,553,530.00	3,103,809.34	10,449,720.66	13,560,000.00	6,780,000.00	1,695,000.00
	Нийт дүн		377,017,720.00 (гурван зуун далан долоон сая арван долоон мянга долоон зуун хорин)	82,399,633.13 (нааян хоёр сая гурван зуун ерэн есөн мянга зургаан зуун гучин гурван төгрөг арван гурван мөнгө)	294,618,086.8 7 (хоёр зуун ерэн дөрвөн сая зургаан зуун арван найман мянга нааян зургаан төгрөг нааян долоон мөнгө)	377,060,000.00 (гурван зуун далан долоон сая жаран мянган)	188,530,000.00 (нэг зуун наян найман сая таван зуун гучин мянган)	33,807,500.00 (гучин гурван сая найман зуун долоон мянга таван зуун)